ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН
ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2024/16/-НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН**

Зуунмод 2024 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.ХишигжаргалУтас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn Аудитын менежер О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mnАудитор Б.Одбилэг
Утас: 70272582 Цахим хаяг: odbilegb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийгдараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 18
4.1 Ерөнхий зүйл ..... 18
4.2 Материаллаг байдал ..... 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 19
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 20
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТЭЛ

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ИТХ | Иргэдийн төлөөлөгчдийн Хурал |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| МУЕА | Монгол улсын Ерөнхий аудитор |

## 1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

2024.02.22 № 01/49

танай ______ оны № ______-т

ТӨВ АЙМГИЙН БҮРЭН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГА Б.ОТГОНХИШИГТ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Лүн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газар нь сумынхаа эдийн засаг, нийгмийн хөгжлийг тогтвортой ахиулах, оновчтой бодлого, зохицуулалтаар хангах замаар сумынхаа хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго тавьж ажиллажээ. Тайлант онд орон нутгийн хөгжлийн сан болон төсвийн хөрөнгөөр 172,605.9 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэж санхүүгийн тайланд бүрэн тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц ХИШИГЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 66,673,762.40 | 72,331,474.30 |
| 33 | АВЛАГА | 200,467.30 | 181,228.60 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 0.00 | 19,761.30 |
| 335 | Бусад авлага | 200,467.30 | 161,467.30 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 26,467.30 | 26,467.30 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 174,000.00 | 135,000.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 66,473,295.10 | 72,150,245.70 |
| 351 | Түүхий эд материал | 352,500.00 | 352,500.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 352,500.00 | 352,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 62,420,795.10 | 62,997,745.70 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,993,800.00 | 2,198,750.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 15,850,582.70 | 18,577,582.70 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 0.20 | 0.80 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 44,576,412.20 | 42,221,412.20 |
| 35600 | Мал амьтад | 3,700,000.00 | 8,800,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 3,313,874,195.40 | 3,354,901,958.40 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 3,313,874,195.40 | 3,354,901,958.40 |
| 392 | Биет хөрөнгө | 3,152,518,624.10 | 3,194,996,030.00 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,213,267,198.40 | 3,304,855,198.40 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -452,400,245.50 | -516,683,190.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 210,898,855.00 | 236,040,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -139,757,937.80 | -149,397,083.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 97,418,326.00 | 101,492,358.80 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -51,184,450.50 | -53,921,343.40 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 104,645,667.50 | 112,175,667.50 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -51,917,602.00 | -60,630,690.30 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -1,956,950.00 | -2,000,000.00 |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 23,986.00 | 23,986.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 339,877,311.00 | 362,124,811.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -118,395,534.00 | -141,083,685.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 161,355,571.30 | 159,905,928.40 |
| 39301 | Програм хангамж | 1,713,000.00 | 1,713,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -1,488,000.00 | -1,600,500.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 176,582,000.00 | 176,582,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -15,451,428.70 | -16,788,571.60 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 3,380,547,957.70 | 3,427,233,432.70 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 425,900.00 | 0.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 425,900.00 | 0.00 |
| 413 | Өглөг | 425,900.00 | 0.00 |
| 4136 | Бусад өглөг | 425,900.00 | 0.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 425,900.00 | 0.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 3,380,122,057.70 | 3,427,233,432.70 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 3,380,122,057.70 | 3,427,233,432.70 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 627,926,463.80 | 627,926,463.80 |
| 51101 | Өмч: - төрийн | 627,926,463.80 | 627,926,463.80 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 2,470,714,595.20 | 2,517,825,970.20 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 2,470,714,595.20 | 2,470,714,595.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 47,111,375.00 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 281,480,998.80 | 281,480,998.80 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 3,380,547,957.70 | 3,427,233,432.70 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 914,250,405.70 | 1,015,243,365.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 479,198,114.00 | 149,588,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 479,198,114.00 | 149,588,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 479,198,114.00 | 149,588,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 218,120,000.00 | 0.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 261,078,114.00 | 149,588,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 435,052,291.70 | 865,655,365.70 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 45,571,691.70 | 192,326,865.70 |
| 131103 | ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,560,000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,132,200.00 | 192,326,865.70 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,780,000.00 | 0.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | 16,099,491.70 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 389,480,600.00 | 673,328,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 389,480,600.00 | 673,328,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 701,073,894.00 | 968,131,990.70 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 608,503,370.80 | 812,622,361.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 543,624,486.00 | 768,737,906.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 209,397,265.40 | 402,639,346.40 |
| 210101 | Үндсэн цалин | 167,423,354.70 | 290,766,036.90 |
| 210102 | Нэмэгдэл | 33,652,020.70 | 98,164,660.90 |
| 210104 | Урамшуулал | 8,321,890.10 | 11,571,901.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 2,136,747.10 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,903,974.20 | 50,552,990.70 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,500,942.90 | 34,697,796.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,164,898.20 | 4,082,093.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,715,118.50 | 3,455,728.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 403,403.90 | 749,366.50 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,119,610.70 | 7,568,005.80 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 51,330,456.40 | 72,648,668.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,151,860.00 | 12,863,029.40 |
| 210302 | Түлш, халаалт | 41,166,599.40 | 56,203,487.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,011,997.00 | 3,582,152.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30,969,693.00 | 33,293,440.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,551,740.00 | 2,317,790.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,317,953.00 | 27,991,380.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,200,000.00 | 2,030,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,900,000.00 | 953,470.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,500,000.00 | 988,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 988,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,797,500.00 | 5,346,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,797,500.00 | 5,346,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 24,262,669.70 | 10,783,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 23,357,039.70 | 10,034,934.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 0.00 | 64,350.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 253,676.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,830.00 | 110,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 196,462,927.40 | 192,485,300.60 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 28,551,050.00 | 63,717,690.30 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 167,911,877.40 | 128,767,610.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 64,878,884.70 | 43,884,454.40 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,589,500.00 | 17,165,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,560,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,129,500.00 | 17,165,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 900,000.00 | 0.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 44,289,384.70 | 26,718,554.40 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,289,384.70 | 26,718,554.40 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 92,570,523.20 | 155,509,629.70 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 92,570,523.20 | 155,509,629.70 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 33,584,174.00 | 0.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 58,986,349.20 | 155,509,629.70 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 213,176,511.70 | 47,111,375.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 863,319.90 | 0.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 863,319.90 | 0.00 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -863,319.90 | 0.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 212,313,191.90 | 47,111,375.00 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 652,697,291.70 | 865,655,365.70 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 217,242,500.00 | 0.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 217,242,500.00 | 0.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 218,120,000.00 | 0.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 218,120,000.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 435,454,791.70 | 865,655,365.70 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 45,974,191.70 | 192,326,865.70 |
| 131103 | ЗГНХ, ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 7,560,000.00 | 0.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 20,534,700.00 | 192,326,865.70 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,780,000.00 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 389,480,600.00 | 673,328,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 389,480,600.00 | 673,328,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 434,577,300.50 | 671,494,071.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 434,577,300.50 | 671,494,071.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 369,398,415.80 | 627,609,616.60 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 209,397,265.40 | 402,585,672.30 |
| 210101 | Үндсэн цалин | 167,423,354.70 | 291,054,214.70 |
| 210102 | Нэмэгдэл | 33,652,020.70 | 97,922,809.00 |
| 210104 | Урамшуулал | 8,321,890.10 | 11,471,901.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 2,136,747.10 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 26,903,974.20 | 50,561,455.10 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 18,500,942.90 | 34,447,521.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,164,898.20 | 4,052,689.80 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,715,118.50 | 3,432,205.80 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 403,403.90 | 810,537.30 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,119,610.70 | 7,818,501.20 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 50,452,956.40 | 72,648,668.90 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5,151,860.00 | 12,863,029.40 |
| 210302 | Түлш, халаалт | 40,289,099.40 | 56,203,487.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,011,997.00 | 3,582,152.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 22,221,800.00 | 30,033,485.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,276,000.00 | 2,968,640.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,845,800.00 | 22,148,600.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,200,000.00 | 2,030,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,900,000.00 | 2,885,445.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,500,000.00 | 4,599,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,500,000.00 | 4,599,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 2,856,100.00 | 5,346,400.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,856,100.00 | 5,346,400.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 25,598,884.80 | 10,783,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 24,408,454.80 | 10,034,934.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 604,800.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 284,800.00 | 97,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 243,676.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 50,830.00 | 87,500.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,467,435.00 | 51,051,175.30 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 30,467,435.00 | 51,051,175.30 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 65,178,884.70 | 43,884,454.40 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 20,889,500.00 | 17,165,900.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,560,000.00 | 0.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 12,129,500.00 | 17,165,900.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,200,000.00 | 0.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 44,289,384.70 | 26,718,554.40 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,289,384.70 | 26,718,554.40 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 218,119,991.20 | 194,161,294.70 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 218,119,991.20 | 194,161,294.70 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 218,119,991.20 | 194,161,294.70 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 218,119,991.20 | 194,161,294.70 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 51,766,311.60 | 0.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 54,857,179.60 | 179,161,394.70 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 111,496,500.00 | 14,999,900.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Код |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 627,926,463.77 | 281,480,998.79 | 2,470,714,595.18 | 0 | 3,380,122,057.74 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| C0 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| C0 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 627,926,463.7 7 | 281,480,998.7 9 | 2,470,714,595.18 | 0 | 3,380,122,057.7 4 |
| C0 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| C0 5 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| C0 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| C0 7 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| C0 8 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 627,926,463.7 7 | 281,480,998.7 9 | 2,470,714,595.18 | 0 | 3,380,122,057.7 4 |
| D0 1 | 2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл | 627,926,463.7 7 | 281,480,998.7 9 | 2,470,714,595.18 | 0 | 3,380,122,057.7 4 |
| D0 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| D0 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 627,926,463.7 7 | 281,480,998.7 9 | 2,470,714,595.18 | 0 | 3,380,122,057.7 4 |
| D0 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| D0 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| D0 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| D0 7 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| D0 8 | Тайлант үеийн үр дүн | 0 | 0 | 47,11,374,97 | 0 | 47,11,374,97 |
| D0 9 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 627,926,463.7 7 | 281,480,998.7 9 | 2,517,825,970.15 | 0 | 3,427,233,432.7 1 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

(төгрөгөөр)

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0.00 | 0.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 645,017,900.00 | 583,125,342.18 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 645,017,900.00 | 583,125,342.18 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 576,354,300.00 | 565,959,442.18 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 384,608,300.00 | 381,365,187.32 |
| 210101 | Үндсэн цалин | 331,717,800.00 | 288,292,777.71 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 210104 | Урамшуулал | 0.00 | 11,471,901.60 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 0.00 | 2,136,747.06 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,076,100.00 | 47,718,840.95 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 32,691,700.00 | 32,643,779.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,846,100.00 | 3,840,484.91 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,076,900.00 | 3,072,388.37 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 769,200.00 | 768,096.31 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,692,200.00 | 7,394,091.54 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 75,414,500.00 | 72,648,668.91 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 6,967,900.00 | 12,863,029.41 |
| 210302 | Түлш, халаалт | 67,565,800.00 | 56,203,487.50 |
| 210304 | Байрны түрээс | 0.00 | 0.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 27,447,300.00 | 24,532,585.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,000,000.00 | 2,542,740.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 17,247,300.00 | 17,073,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 0.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 0.00 | 0.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 0.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,600,000.00 | 4,599,300.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 0.00 | 0.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | 0.00 | 0.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 10,570,000.00 | 10,248,460.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 9,500,000.00 | 9,499,934.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 320,000.00 | 320,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 400,000.00 | 97,350.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 250,000.00 | 243,676.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 0.00 | 0.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,291,700.00 | 19,500,000.00 |
| 212201 | Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас | 0.00 | 0.00 |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | 0.00 | 0.00 |
| 213206 | Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт | 0.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 0.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 83,500,000.00 | 73,458,938.00 |
| 221001 | Их засвар | 0.00 | 0.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 15,000,000.00 | 14,999,900.00 |
| 232001 | Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл | 0.00 | 0.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | 0.00 | 0.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 688,621,200.00 | 673,328,500.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | 0.00 | 0.00 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 25.00 | 25.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 8.00 | 8.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15 | 15 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 25,271,835.00 | 52,930,174.45 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 25,271,835.00 | 52,930,174.45 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 17,511,835.00 | 52,930,174.45 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 21,220,484.97 |
| 210101 | Үндсэн цалин | | 2,761,436.95 |
| 210102 | Нэмэгдэл | | 18,459,048.02 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 2,842,614.15 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 1,803,741.22 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | | 212,204.85 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | | 359,817.42 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | | 42,440.97 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | | 424,409.69 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,166,400.00 | 5,500,900.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,166,400.00 | 425,900.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | | 5,075,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 535,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 535,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,345,435.00 | 22,831,175.33 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,345,435.00 | 22,831,175.33 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 7,760,000.00 | 0.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 7,760,000.00 | 0.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,560,000.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 0.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | | 120,702,356.66 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | | 120,702,356.66 |
| 223001 | Бусад хөрөнгө | | 120,702,356.66 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 25,271,835.00 | 192,326,865.66 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 25,271,835.00 | 192,326,865.66 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,527,660.00 | 192,326,865.66 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газар нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д "Аймаг, сум,нийслэл, дүүргийн Засаг даргын ажлын алба нь тамгын газар байх бөгөөд доор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу 67.1.1-67.1.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ-ын даргын 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн А/01 дүгээр тушаалаар удирдах 3, гүйцэтгэх 18, гэрээт 4 ажилтан, нийт 25 орон тоотой баталж, үйл ажиллагаагаа явуулсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь үйл ажиллагаандаа олон улсын чанарын менежментийн тогтолцоо ISO стандартыг нэвтрүүлэхээр "Менежмент ба арга зүйн төв" ТББ-тай гэрээ байгуулан ажилласан байна.

Бүрэн сумын ЗДТГ-ын 15 ажлын байр, албан тушаалын чиг үүрэгт шинжилгээ хийж чиг үүргийн давхардалгүй ажиллаж байна.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хөдөлмөрийн тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотойгоор Бүрэн сумын ЗДТГ нь хөдөлмөрийн дотоод журам болон холбогдохбаримт бичигт орсон өөрчлөлтийг тусган мөрдөж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартайбайдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, шаардлагагүй гэж үзсэн.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн хэмжээнд Санхүү төрийн сангийн хэлтсээс

баталсан нББ-ын бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйлажиллагааны онцлогт тохирсон байна

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт оруулаагүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөхоноос 46.685,4 мянган төгрөгөөр буюу 1,4 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 200.5 | 181.2 | (19.2) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 66,473.3 | 72,150.2 | 5,677.0 |
| Үндсэн хөрөнгө | 3,313,874.2 | 3,354,902.0 | 41,027.8 |
| Нийт хөрөнгө | 3,380,548.0 | 3,427,233.4 | 46,685.5 |
| Өр төлбөр | 425.9 | - | (425.9) |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3,380,122.1 | 3,427,233.4 | 47,111.4 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | 3,380,548.0 | 3,427,233.4 | 46,685.5 |

Дээрх хүснэгтээс харахад

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 46,685.5 мянган төгрөгөөр буюу 1,4 хувиар өссөн байна.

Бараа материал дансны хувьд бичиг хэргийн материал 204.9 мянган төгрөг, аж ахуйн материал 2,727.0 мянган төгрөг, түлш, шатах тослох материал 1.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, бусад хангамжийн материал 2,355.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд барилга байгууламж, орон сууц 91,588.0 мянган төгрөг, тээврийн хэрэгсэл 25,141.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 4,074.0 мянган төгрөгөөр нэмэгдэж, акталсан 22,025.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 15,000.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 7,530.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 5,588.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 91,588.0 мянган төгрөгийн барилга байгууламж, орон сууц, 32,900.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 20,000.0 мянган төгрөгийн бусад үндсэн хөрөнгө хүлээн авч, үндсэн хөрөнгө данс нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,427,233.0 мянган төгрөг болж 47,111.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 675,525.8 мянган төгрөг, зарлагыг 675,525.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ-ын хүргүүлсэн төсвийн төслөөс 95,294.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж, аймгийн ИТХ-ын 2022 оны 13 дугаар тогтоолоор 752,820.4 мянган төгрөг, 2023 оны ээлжит бус 6 дугаар хуралдааны тогтоолоор 740,768.8 мянган төгрөгөөр тодотгон баталсан байна.

Тайлант хугацаанд сумын ИТХ-ын 2023 оны 08 дугаар сарын 14-ний өдрийн хуралдааны 02 тоот тогтоолоор тодотгол хийж, нийт 68,500.0 мянган төгрөгийн төсөл арга хэмжээг сумын шилжих үлдэгдлээс санхүүжүүлэхээр тодотгол оруулж нийт зардлыг 604,828.3 мянган төгрөгөөр, зардал санхүүжүүлэх эх үүсвэрийг 604,828.3 мянган төгрөгөөр орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 389,480.6 мянган төгрөгийг 218,210.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэх 604,700.6 мянган төгрөг, хүрээлэн буй орчны бодлого, удирдлага хөтөлбөрийн 1 арга хэмжээг санхүүжүүлэх 2,900.0 мянган төгрөг, нийт 607,600.6 мянган төгрөгийн зардлыг, орон нутгийн төсвөөс 389,480.6 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 218,120.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсны дагуу гүйцэтгэлээр зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 100 хувь олгож, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 23,587.0 мянган төгрөгийг төсөвт татан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 584,013.6 мянган төгрөг буюу 96,1 хувьтай байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажиллаж, цалингийн зардлаас12,773.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 3,089.1 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 1,301.9 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх бараа үйлчилгээний зардлаас 6,257.7 мянган төгрөг нийт 23,587.0 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг татан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80101 /Үндсэн үйл ажиллагааны зардал | 2023.01.01 2023.12.31 | | | 431,596.8 | 431,596.8 |
| 2 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80103 /Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээ | | 12,445.3 | 12,445,3 |
| 3 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80106 /Баг, хорооны үйл ажиллагааны зардал | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Баг, хорооны үйл ажиллагааны зардал | | 106,220.5 | 106,220.5 |
| 4 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80802 /Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Ажил олгогчоос олгох тэтгэмж, | | 17,165.9 | 17,165.9 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | урамшуулал, дэмжлэг | | | |
| 5 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-80918 /Бусад | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Бусад | | 83,500.0 | 83,500.0 |
| 6 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81102 /Орон нутгийн нөөц хөрөнгө | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Орон нутгийн нөөц хөрөнгө | | 5,000.0 | 5,000.0 |
| 7 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | | 2,900.0 | 2,900.0 |
| 8 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-81701 /Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх | | 9,500.0 | 9,500.0 |
| 9 | 70106 /Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага/-82212 /Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | 2023.01.01 2023.12.31 | Орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлага-Хур хог хаягдал, орчны бохирдлыг устгах, цэвэрлэх үйлчилгээ | | 5,000. | 5,000. |
| | **Дүн** | | | | **673,328.5** | **673,328.5** |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газар нь 2023 онд нэмэлт санхүүжилтийн дансанд аймгийн хөрөнгө оруулалтын барьцаа сангаас Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийн санхүүжилт 100,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргаас автомашины засварт 5,500.0 мянган төгрөг, онцгой байдлын штабд шатахууны дэмжлэг 5,000.0 мянган төгрөг,Статистикийн хэлтсээс ээлжит тооллогын болон тандалт судалгааны зардалд 1,102.8 мянган төгрөг, ТАХ-д олгох орон нутгийн нэмэгдэлд 33,796.2 мянган төгрөг, өвсний үнэнд 19,459.5 мянган төгрөг, өмнөх оны татан төвлөрүүлсэн нэмэлт санхүүжилтийн орлого 20,702.3 мянган төгрөг, бусад орлого 6,720.5 мянган төгрөг нийт 192,326.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж холбогдох зардлуудад зориулалтын дагуу зарцуулсан байна. Тайлант онд зарцуулаагүй 9,974.3 мянган төгрөгийг татан төвлөрүүлж тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн орлого, зардлыг зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр 100,700.0 мянган төгрөг батлагдсан байна. Гүйцэтгэлээр 74,744.5 мянган төгрөгийн худалдан авалтыг худалдан авах ажиллагааны журмын дагуу зохион байгуулсан

байна. Худалдан авалтын дүн өссөн нь төсөв тодотгон нэмэгдсэнтэй холбоотой байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Одбилэг гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 03/33 тоот албан бичгээрТөв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Бүрэн сумын ЗДТГ-ын 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Бүрэн сумын ЗДТГ-ын батлагдсан 2022 оны үр дүнгийн тайлангийн нийт орлого 914,250.4 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 13,713.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 10,971.0 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Бүрэн сумын ЗДТГ нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох гэсэн" заалтыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл 9,964,7 мянган төгрөг олгосон байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын Тамгын газрын шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт 166 мэдээлэл байршуулахаас 166 мэдээллийг бүрэн

байршуулж шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

## 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад ямар нэгэн алдаа зөрчил илрээгүй байна.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 2 төлбөрийн акт, 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 03/144 тоотоор Төв аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

*Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт*

(мянган төгрөгөөр)

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 2 | 1,070.8 | 2 | 1,070.8 | 100% |
| Албан шаардлага | 1 | 4,122.0 | 1 | 4,122.0 | 100% |
| Зөвлөмж | 2 | 15,300.0 | 2 | 15,300.0 | 100% |
| Нийт дүн | 5 | 24,084.9 | 5 | 24,084.9 | 100% |

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудлаар орон нутгийн шилжих үлдэгдлээс санхүүжүүлж байгаа хөрөнгийн зардлын зарцуулалт болон нэмэлт санхүүжилтийн данснаас төрийн албан хаагчдыг орон сууцжуулах хөтөлбөрийн хүрээнд 100,000.0 мянган төгрөг санхүүжүүлснийг хэрхэн хэрэгжүүлж зарцуулсан байдлыг тодорхойлж байна. Мөн "Монголын баялаг 330" төсөл хөтөлбөрийн хүрээнд соёлын өвийг дүрсжүүлэн архив, үүсгэх ажлын гэрээний дагуу Монголын баялаг өв соёл ХХК-д 3,879.6 мянган төгрөг шилжүүлсэн байна. Холбогдох баримт материалыг хүлээн авч орлого болгосон талаарх асуудлыг авч үзэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Бүрэн сумын Засаг даргын тамгын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайлангийн аудитаар 12,810.5 мянган төгрөгийн алдаа нийт 9,964.8 мянган төгрөгийн зөрчил илрүүлснийг дараах байдлаар шийдвэрлэлээ.

### 5.1 Залруулсан алдаа

Аудитаар санхүүгийн үр дүнгийн тайланд элэгдлийн зардал 2,810.5 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 10,000.0 мянган төгрөгөөр, нийт 12,810.5 мянган төгрөгийн алдааг залрууллаа.Үүнд:

***1,Илрүүлэлт:*** Үр дүнгийн тайланд орлого болон үнэ төлбөргүй хүлээн авсан үндсэн хөрөнгийн дүнг 10,000.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 20.2.5, "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 20.2.6 "Эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга

***2.Илрүүлэлт:*** Санхүүгийн тайлангийн бүрэлдэхүүн уялдааг тулгаж үзэхэд мөнгөн гүйлгээний тайланг 2,810.5 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна. Энэ нь НББ-ийн тухай хуулийн 8 дугаар зүйл "Санхүүгийн тайлан " гэсэн заалтыг зөрчсөн байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга

Аудитаар нийт 9,964.8 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 9,964.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж ажиллалаа.

### 5.2 Төлбөрийн акт

Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгоно гэсэн Монгол улсын Засгийн газрын тогтоолыг зөрчиж улс төрийн албан хаагчдад орон нутгийн нэмэгдэл олгож төсвийг үр ашиггүй зарцуулсан зөрчил илэрлээ

***1.Илрүүлэлт:*** Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-д "Хариуцлагатай байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 489 дүгээр "Тогтоолд нэмэлт оруулж, тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай " тогтоол 018 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 382 дугаар "Журам батлах тухай" тогтоол болон санхүүгийн тайлангийн аудитын "нийцсэн бөгөөд зохистой байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол төлбөрийн акт тогтооно гэсний дагуу шийдвэрлэв.

### 5.3 Албан шаардлага

***1.Илрүүлэлт:*** Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн "Хөрөнгийн тооллого хийх тухай" А/09 тушаал гарч эд хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодож үлдэгдлийг баталгаажуулаагүй зөрчил илэрлээ.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2-д "Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-ээс/", мөн хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.4-д "Комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ерөнхий нягтлан бодогчид тусгай жагсаалтаар шилжүүлэн өгөх" гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "Эрх ба үүрэг", "Тасалбар болголт", "Оршин байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***Шийдвэрлэсэн нь:*** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.8-д "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т заасан бусад нөхцөл байдал үүссэн" бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлагналтай холбоотой алдаа | 2 | 12,810.5 | | | 2 | 12,810.5 | 2 | 12,810.5 | | | | |
| Дүн | 2 | 12,810.5 | | | 2 | 12,810.5 | 2 | 12,810.5 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

| Алдааны товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Улс төрийн албан хаагчдад журам зөрчиж орон нутгийн нэмэгдэл олгосон байна | 1 | 9,964.8 | 1 | 9,964.8 | | | | | | | | |
| Хөрөнгийн тооллого хийсэн боловч тооцоо бодож баталгаажуулаагүй байна. | | | | | 1 | | | | | | | |
| Дүн | 1 | 9,964.8 | 1 | 9,964.8 | 1 | | | | | | | |